

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА ЛУВСАНСАМДАНГИЙН ОЧГЭРЭЛИЙН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					
1	2	3	4	5	6	7				
<b>Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадвахыг бэхжүүлэх”</b>										
1	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцон эрсдэлийг бууруулах талаар авсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийг тооцох, бууруулах чиг үүрэг нэмэгдсэн.	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцож, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.	1. Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тушаалаар ГЕГ-ын даргын шууд удирдлага дор Дотоод хяналт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж нь “ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээнд <b>гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах</b> ... үндсэн чиг үүрэг хүлээнэ” гэж заасныг үндэслэн ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын дарга нарын ажлын байрны тодорхойлолтод дээрх асуудлыг тусгуулах санал хүргүүлж ажиллалаа. Мөн ДХАБХ-ийн дарга Л.Очгэрэлээс 2024 оны 05-р сарын 02-ны өдрийн 01-5/1741 тоотоор “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” чиглэл хүргүүлж ажиллалаа. 2. Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаал, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2024 оны 03-р сарын 13-ны өдрийн 03/01 дугаар шийдвэрийн дагуу бүтцийн нэгжийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг батлахтай холбоотойгоор өөрийн нэгжийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг боловсруулж, ХШУДАГ-т дотоод зурвасаар хүргүүлж ажилласан байна.	01-01 06-05	100			

3. Чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс болон харьяа газар, хороодоос нэгжийн үйл ажиллагаанд тус хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу эрсдэл тооцож ажилласан талаарх тайланг хүлээн авч нэгтгэн ажиллалаа. Тайланг нийт 19-н газар, хороодоос ирүүлсэн байна. Үүнд нийт нэгжийн үйл ажиллагааны үндсэн эрсдэлийг дүгнэхэд 1-рт хүний нөөцийн эрсдэл, 2-рт гадна орчны эрсдлэл гэж тодорхойлж болохоор байна. /ирүүлсэн тайланг цахим сүлжээнд хавсаргав/
4. ЗҮ боомтоор УХ-р нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлд эрсдэл тооцож, бүртгэлгүй 242 тээврийн хэрэгслийг шалгаж, АТТ болон чиг үүргийн ажлаа хуулийн дагуу хэрэгжүүлээгүй 14-н ГУАБ-ийг сахилгын хороонд шилжүүлж, эхний 5-н ГУАБ-д сахилгын шийтгэл ногдуулсан. Бүргэлгүй УХ-р тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн дээрх 14-н ГУАБ-ийг шалгуулахаар ЦЕГ, АТГ-т шилжүүлсэн.
5. ДХАБХ-ийн дарга Л.Очгэрэл нь өглөө бүр “гаалийн хэвлэлийн тойм”-мэдээлэлтэй танилцаж, гаалийн байгууллагын Үйл ажиллагаа, ГУБ-ын сахилга ёс зүй, бараа тээврийн хэрэгслийн хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, татвараас зайлсхийх үйлдэлтэй холбоотой мэдээллийг өөрийн нэгжийн албан хаагчдаар тухай бүр шуурхай нягтлан шалгаж, шийдвэрлэж байна.

Тухайлбал: Нэгүн.mn сайтын сошалд тавьсан мэдээллийн дагуу албаны шалгалт хийж, ЧХОУНБГГ-ийн нэр бүхий 3-н албан хаагчдын үйл ажиллагаанд албаны шалгалт хийж, гэм буруутай байх үйлдлийг тогтоож, АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн байна.

Мөн ЧХОУНБГГ-ын ГУБ нартай холбоотой бредийн цүнх, гоёл чимэглэлийн /алтан/ зүйлсийг ГУБ хулгайлсан гэх, УХШИГГ-ын ГУБ нар гоо сайхны бараа, гоёл чимэглэлийн зүйлсийг хулгайлсан гэх үйлдлийг тус тус шалгаж, ГУБ нарын гэм буруугүйг тогтоож, Хэвлэл мэдээллийн төвөөр дамжуулан олон нийтэд танилцуулсан.

Уг ажлын хүрээнд ЧХОУНБГГ, УХШИГГ-уудын “гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрсдэлтэйд тооцож, хяналт шалгалтын технологи ажиллагаа зөрчигдсөн” талаар мэдээлэл бэлтгэн, гаалийн хяналтын

			үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг өгч, албан тоот хүргүүлж, зөрчлийг арилгуулсан.			
2	Аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалын дагуу шинээр нэмэгдсэн чиг үүрэг.</p> <p>- Мэдээллийн болон программ хангамж, дотоод сүлжээний аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <p>- Барилга байгууламж, хөдөлмөрийн болон албаны нууцтай холбоотой бүх төрлийн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <p>- Байгууллагын албан хаагчдын аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.</p>	<p>1. 2024 оны 1 сард зохион байгуулгасан “Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн 2023”-т оролцох харьяа гаалийн байгууллагын удирдах ажилтнуудын дунд Viber групыг нээж ажиллуулж, харьяа гаалийн газар хороодын өдөр тутмын хэвийн ажиллагаанд хяналт тавьж, мэдээлэл авч аюулгүй байдлын зөвлөмж өгч ажилласан.</p> <p>2. Монгол Улсын Засгийн газраас цас зудны аюулаас урьдчилан сэргийлэх “Өндөржүүлсэн бэлэн байдал” зарласантай холбоотойгоор харьяа гаалийн газар хороодын дарга наартай Viber групп нээж цаг үеийн үүссэн нэхцэл байдлын мэдээллийг түргэн шуурхай авч байх, авч хэрэгжүүлж буй ажлыг цаг алдалгүй удирдлагад танилцуулж мэдээ, мэдээллийг Захиргааны удирдлагын газарт өгч, Сангийн яаманд өгөх тайланда оруулж ажиллалаа. Цаашид энэ Viber групп нь цаг үеийн шинжтэй үйл ажиллагаатай холбоотойгоор мэдээллийг түргэн шуурхай солилцох, шаардлагатай арга хэмжээг яаралтай авах, ажлын чиглэл хүргүүлэх, зорилготой юм.</p> <p>3. Нэгж бүрт аюулгүй байдал хариуцсан албан хаагчийг томилуулж, бүртгэлийн сан үүсгэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах талаар албан тоот хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Харьяа газар хороодоос ажлын шаардлагаар болон хувийн ажлаар хөдөө орон нутгаас ирж, буцахдаа албан хаагчид аюулгүй зорчих санамжийг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулж байх, ажилд гарагад аюулгүй ажиллагааны журам, зааврыг танилцуулж, батгалгааны хуудас дээр гарын үсэг зуруулж байх чиглэл өгсний дагуу хэрэгжин байна.</p> <p>4. “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөтөлбөрт гаалийн байгууллагаас хамрагдаж буй ахлагч болон сургагч багш наарт “албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишиг, манлайлал үзүүлж, хувь хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах” чиглэлийг өгч, батгалгааны хуудас гаргуулсан. Мөн гадаад сургалтад хамрагдаж буй</p>	01-01 06-05	100

					<p>албан хаагчдад дээрх баталгааг гаргуулсан. (АНУ-руу явсан 10 албан хаагч)</p> <p>5. Албан хаагчдаас хандив цуглуулах, мөнгөн туслалцаа авах талаар "Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйл"-д заасан заалтуудын дагуу зөвлөмж бэлтгэн, гаалийн байгууллагын дотоод сүлжээнд байршуулан ажиллалаа.</p>		
3	Гаалийн улсын байцаагчийн сахилга, ёс зүйн хяналт, шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой нийт 56 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж, хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэсэн байна.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаа болон албан хаагчидтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл шалгагдаж шийдвэрлэгдсэн байна. Хэрэгжилтэд хяналт тавьсан байна.	<p><b><u>Тус хэлтсээс нийт 85 /давхардсан тоо/ албан хаагчидтай холбоотойгоор шалгасан гомдол, мэдээллийг товч байдлаар дурдвал:</u></b></p> <p>1. Гашуунсухайт дахь гаалийн газраас 2024 оны 01 сарын 30-ны өдөр 01/30, тоот албан бичгээр тус газрын ГУАБ А.Г, ГУБ Г.Н, Ж.Ц нарт холбогдох ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулсан. Тус шалгалтаар дээрх ГУБ нарын ёс зүйн зөрчил тогтоогоогүй бөгөөд, харин ГУАБ А.Г-гийн хувьд тус газраас зан харилцааны доголдолтой гэж тодорхойлсон бөгөөд тус асуудлыг удирдлагын түвшинд танилцуулж шийдвэрлүүлсэн. Тус гомдол мэдээлэлтэй холбоотойгоор Гашуунсухайт дахь гаалийн газарт 01-2/688 тоот ажлын чиглэлийг хургуулсан.</p> <p>2. Мөн 01/31 тоот албан бичгээр тус газрын ГУБ Г.С нь Ухаа-Худаг дахь Энержи ресурс ХХК-ийн кемпийн дотоод журмыг зөрчсөн талаарх гомдол мэдээлэл ирүүлснийг Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсээс шалгах ажиллагаа явуулсан бөгөөд үр дүнг удирдлагын түвшинд танилцуулж шийдвэрлүүлсэн. Тус гомдол мэдээллийн хүрээнд Гашуунсухайт дахь гаалийн газарт 01-2/688 тоот албан бичгээр ажилтан албан хаагчдын ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар ажлын чиглэлийг өгсөн бөгөөд Санхүү хөрөнгө оруулалтын газарт №24/12 тоот зурvasaар хил дээр ажиллаж амьдарч байгаа ГУБ нарын амьрах орчин нөхцөлийг сайжруулах, ар гэрийн хамт амьдрах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой эсэхийг судалж үзэх талаар дотоод зурvasaыг хургуулсан.</p>	01-01 06-05	100

3. Баян-өлгий аймаг дахь гаалийн газраас тус газрын хорио цээр, эрүүл ахуйн ГУАБ К.С-д холбогдох ажил тасалсан гэх мэдээллийг 2024 оны 01 сарын 04-ны өдөр тус хэлтэст ирүүлснийг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг бүрдүүлэн сахилгын хороогоор хэлэлцүүлэхээр шилжүүлсэн.
4. Гашуунсухайт дахь гаалийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 01/132, тоот албан бичгээр тус газрын ГУБ Ц.Д-т холбогдох ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулсан. Тус шалгалтаар дээрх ГУБ-д ёс зүйн зөрчил тогтоогдоогүй бөгөөд тус асуудлыг удирдлагын түвшинд танилцуулж шийдвэрлүүлсэн.
5. Замын-Үүд дэх гаалийн газрын ГУБ Л.Н нь Зөрчилтэй тэмцэх газраас дахин шалгалт хийх тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсээс гаргаж явуулсан талаарх Зөрчилтэй тэмцэх газраас ирүүлсэн мэдээллийн дагуу холбогдох албан хаагчдаас тайлбар авч албаны дотоод шалгалт явуулахад санаатай гаргаж явуулсан үйлдэл тогтоогдоогүй тул тус мэдээллийн танилцуулгыг бэлтгэн Зөрчилтэй тэмцэх газрын даргад танилцуулсан.
6. Чингис Хаан ОУНБДГГ-ын ГУБ Б.Б-д холбогдох сахилгын шийтгэлийг хүчингүй болгож шинээр илэрсэн нөхцөл байдлын хүрээнд албаны дотоод шалгалтыг явуулж, танилцуулга бэлтгэн удирдлах албан тушаалтанд хүргүүлж, уг зөрчилд холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулсан байна.
7. Замын-Үүд дэх гаалийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/255 дугаартай албан бичгээр ирүүлсэн тус газрын хяналт шалгалт хариуцсан ГУАБ Ж.М, ГУБ Л.Д нарт холбогдох гаалийн хяналт шалгалтыг дутуу хийж, бусдад гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэх материалыг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг бүрдүүлэн сахилгын хороогоор хэлэлцүүлэхээр шилжүүлсэн.
8. Замын-Үүд дэх гаалийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/255 дугаартай албан бичгээр ирүүлсэн тус газрын хяналт шалгалт хариуцсан ГУАБ

					<p>Ж.М, ГУБ С.Ц нарт холбогдох гаалийн хяналт шалгалтыг дутуу хийж, бусдад гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэх материалыг хүлээн авч албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг бурдуулэн сахилгын хороогоор хэлэлцүүлэхээр шилжүүлсэн.</p> <p>9. Улаанбаатар хот дахь гаалийн газраас ирүүлсэн дахин шалгалт хийсэн мэдээллийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Техник импорт дахь гаалийн хяналтын бүсэд иргэн Л.Ч-гийн мэдүүлсэн бараанд Гаалийн ерөнхий газраас дахин шалгалт хийхэд 21,140,622.61 төгрөгийн татвар нөхөн төлүүлж 10,570,311.31 төгрөгийн тогтууль ногдуулсан бөгөөд тус бурдуулэлтэд холбогдох гаалийн улсын ахлах байцаагч Н.Н, М.Б нарт холбогдох албаны дотоод шалгалтыг явуулж холбогдох материалыг сахилгын хороонд хүргүүлсэн.</p> <p>10. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газраас ГУАБ Э.Ж-гийн эрхийг хамгаалж өгнө үү гэх Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газарт гаргасан хүсэлтийг хүлээн авч холбогдо</p> <p>11. Сэлэнгэ дэх гаалийн газрын ТҮ-ний ажилтан Х, ГУБ Т, ГУАБ Б нартай холбоотой зөрчлийн талаар тус газрын ЗТА-ны дарга Б, ГУБ Т нартай утсаар ярьж шинжилгээний нэмэлт материал болон өмнө нь авсан тайлбарыг авч холбогдох ГУБ-д өгсөн.</p>		
4	Гаалийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төлөвлөгөөт бус 6 дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажилласан.	<ul style="list-style-type: none"> <li>- Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.</li> <li>- Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцсон байна.</li> </ul>	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэс иргэн болон байгууллага, ГЕГ-ын 1800-1281 гомдол мэдээлэл хүлээн авах тусгай дугаар, Засгийн газрын 1111 төвөөс нийт 32 гомдол мэдээлэл ирүүлснийг хүлээн авч албаны дотоод хяналт, шалгалт явуулсан бөгөөд шалгагдсан албан хаагчдын талаарх мэдээллийн сан бурдуулж, шалгалтын материалыг архивын нэгж болгон хадгалж байна.</p> <p>Тус 32 гомдол, мэдээлэлтэй холбогдуулан 85 албан хаагчдад /давхардсан тоо/ албаны дотоод шалгалтыг явуулж тайлбар тодруулга авч ажиллаа.</p> <p>Үүнээс сахилга ёс зүйн зөрчилд холбогдсон 25 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахаар Гаалийн ерөнхий газрын салхилгын хороонд холбогдох материалын хамт шилжүүлсэн. ДХАБХ-ээс 4 албан хаагчид холбогдох зөрчлийн танилцуулгыг хүргүүлсний дагуу ГЕГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл</p>	01-01 06-05	100

ногдуулсан байна. Сахилгын хорооны хурлын шийдвэрээр 5 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

- ✓ Гомдол мэдээлэл – 32
- ✓ Шалгагдсан албан хаагч – 85
- ✓ Сахилгын хороонд шийлжүүлсэн – 25
- ✓ Шууд тушаалаар арга хэмжээ авсан – 4
- ✓ Салхилгын хорооноос арга хэмжээ авсан – 5 Нийт арга хэмжээ авагдсан – 9 /Сахилга хариуцлага чиглэлээр/ ёс зүйтэй холбоотой арга хэмжээ авагдсан байхгүй.
- ✓ Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн – 9
- ✓ Гаалийн лавлах 1800-1281 дугаарт ирүүлсэн – 4

Сахилгын шийтгэлийн төрөл нь:

- Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар 20 хувиар бууруулах- 4
- Сануулах – 1
- Албан тушаалыг 3 сарын хугацаагаар бууруулах-1 Гаалийн улсын байцаагчийн эрхийг 6 сарын хугацаатай хасах –3

Ирүүлсэн гомдол мэдээллийг товч байдлаар дурдвал

1. Засгийн газрын 1111 төвд иргэн Б.Оюунзулаас “Гаалийн ерөнхий газрын мэдээлэл лавлагааны хоёр ажилтанд холбогдуулан гомдол гаргаж байна. Бичгээр өгч байгаа өргөдөл гомдлыг аль болох авахгүй байхыг хичээдэг, байгууллагын бичиг баримтаа аваад гаалиар оруулж ирсэн барааны мэдээллээ авах гэхэд цахимаар ав, и-монголиагаар ав гэдэг. Түүнийг ашиглаж мэдэхгүй, цахимаар орсон авч чадахгүй болоод бичгээр авах гэж очиж байгаа шүү дээ. Ажлаа хийдэггүй хоорондоо хов ярьсан хүмүүс л байх юм” гэх гомдлыг хүлээн авч шалгахад иргэн, аж ахуйн нэгж нь мэдээллээ цахимаар авдаг болсон ба энэ талаар тухайн иргэнд тайлбарлаж хэлсэн боловч ойлгохгүй байснаас үл ойлголцох асуудал гарсан болох нь тогтоогдсон ба бичиг хэргийн ажилтан М.Мөнгөнзаяа, Б.Энхжаргал наарт цаашид хэл ам асуудал гаргахгүй ажиллахыг анхааруулан үүрэг болгосон ба гомдол гаргагч Б.Оюунзууд холбогдох хариуг утсаар өгсөн.

2. ГЕГ-ын 1800-1281 дугаар утсаар иргэн Янжиндуламаас ирүүлсэн “ГЕГ-ын бичиг хэрэг дээр ажиллаж байгаа бичиг хүлээн авч байгаа, харилцааны ямар ч соёлгүй хүний үгийг сонсохгүй дахин дахин явуулж байна. Мөн миний бичгийг хүлээн авахаас татгалзсан тул гомдол гаргаж байна. Холбогдох байцаагчтай нь холбогд гээд ямар ч харилцааны соёл алга” гэх гомдлыг хүлээн авч шалган, бичиг хэргийн ажилтан М.Мөнгөнзаяа, Б.Энхжаргал нарт цаашид иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн бичгийг хүлээн авч зохих газарт нь өгч байхыг үүрэг болгон, гомдол гаргагч иргэн Янжиндуламд холбогдох хариуг утсаар өгсөн. Цаашид биечлэн ирж буй иргэдэд бичгээр болон амаар хариуг өгөх боломжийг судалж байна.
3. ГЕГ-ын 1800-1281 дугаар утсаар 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр иргэн С.Өлзийбатаас ирүүлсэн “Дорнод аймгийн гаалийн газрын дарга Гэрэлт-Од-д гомдол гаргаж байна. Энэ нөхөр нь Дорнод аймагт мөрийтэй тоглоом тоглодог. Чойбалсан карго гээд ХАА-н тоног төхөөрөмж оруулж ирдэг компани Ганаа гэдэг захиралтай. Энэ Ганаа гэдэг хүний улсын дугаар 5555 ДОА гэдэг машиныг байнга өөрийн хувийн хэрэгцээндээ унадаг бас оруулж ирсэн бараан дээр нь хөнгөлж татваргүй оруулж ирдэг. Мөн хилээр оруулахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг байнга оруулж ирдэг. Барилгын зарим өндөр татвартай бараан дээр бага татвар оногдуулдаг зэрэг олон асуудлууд гаргаж байгаа тул энэ хүнийг шалгаж өгнө үү.” гэх гомдлыг хүлээн авч хяналт шалгалтын ажиллагааг явуулж, Зерчилтэй тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байна.
4. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас Чоногол трейд ХХК-д бүрдүүлэлтийн дараах шалгалт хийгдэж акт тавьсантай холбогдуулан тус ААН-ээс тус актыг эсэргүүцэн албан бичгээр барааны ангиллын кодыг зөвшөөрсөн гэх гаалийн үнэ үнэлгээ хариуцсан ГУБ нарт албан бичгээр гомдол гаргасан. Тус гомолд дурдсан 8 ГУБ-аас тайлбар мэдээллийг авч “Тухайн компанийн 2019-2022 оны гаалийн бүрдүүлэлттэй холбоотой зөрчлийн хэргийг шалгах ажиллагаа явуулж байна,

				<p>шалгалтын ажиллагаа дуусаагүй байна” гэх 2024 оны 01 сарын 08-ны өдрийн 01-2/64 тоот албан бичгийг ААН-д хариуг хүргүүлсэн.</p> <p>5. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсээс 2024 оны 02 сарын 23-ны өдрийн 05/3489 тоот албан бичгээр Гаалийн ерөнхий газрын харьяа бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн дарга Э.Л-д холбогдох “Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо” ТББ-гаас гаргасан гомдлыг харьяаллын дагуу Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн бөгөөд тус гомдол, мэдээллийн дагуу албаны дотоод шалгалт хийж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрсэн тул Зэрчилтэй тэмцэх газарт шилжүүлсэн.</p> <p>6. МҮ-ын иргэн Θ.Нурбахыт-ийн ирүүлсэн гомдлыг хүлээн авч шалгаад уг гомдолд дурдсан бичиг баримт үнэлгээний байцаагч “тус барааны үнэлгээг хуулийн дагуу хянаж үнэлсэн байна” гэдгийг ГЕГ-ын Барааны, Ангилал Үнэлгээний хэлтсээс дотоод зурvasaар мэдэгсэгдсэн талаар утсаар тайлбарлаж өгсөн. Цаашид гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой гомдлыг БАУХ-ээр шалгуулах асуудлыг удирдлагад танилцуулсан.</p> <p>7. Пэми чөлеөт бус ХХК-аас ирүүлсэн гомдолд дурдсан асуудлыг шалгаж “770” горимоор бүрдүүлэлт хийгдсэн тул гомдлыг хаасан учир гомдол гаргач гомдлоо буцаасан байна.</p> <p>8. Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоонаос ирүүлсэн 2 удаагийн гомдлыг шалгаж, 2024.03.29-ний өдрийн 01-5/1087, 2024.04.23-ны өдрийн 01/5/1537 дугаартай албан бичгүүдээр хариуг хүргүүлсэн.</p> <p>9. МҮ-ын иргэн Д.Цогт-Эрдэнээс ирүүлсэн гомдлыг хянаад “гомдлын дагуу тайлбар бичүүлж авсан бөгөөд Авто тээврийн үндэсний төвөөс тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор /даацыг тодорхойлох/ дүгнэлт гаргуулахыг зөвлөсөн бөгөөд тухайн иргэн энэ талаар тус төвд хандсан боловч дүгнэлт гаргах боломжгүй гэх хариу өгсөн талаар 99828185 дугаартай утсаар залгаж мэдэгдсэн учир гомдолд дурдсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй талаар танилцуулсан болно.</p>	
--	--	--	--	--	--

10. МУ-ын иргэн н.Нэргүйгээс албаны хаягаар ирүүлсэн гомдлыг УХШИГГ-т албан тоотоор шилжүүлсэн.
11. ФЭЙСБҮҮК цахим сүлжээнд "Khaliun Otgonbat" гэх хаягтай иргэнээс хэд хэд удагийн давтамжтай "гаалийнхан ичээчээ дандаа хулгай хийхийн", "...гааль дээр задарсан гээд очоод авахаар дандаа дотроос нь юм дутсан, "... өөр хүний ачаанд андуураад хийсэн", "... та нар зүгээр ич за юу, зүгээр өнгөрүүлээд байхаар арай дэндүү даварч байгаан биш үү", "...гаалийнхан орж ирээд барьж идэх гэж байна шдээ, үнэхээр ой тойнд багтахгүй юм, хахаад үхчихдэггүй юмуу" гэх мэдээлэлтэй холбогдуулан УХШИГГ-ын нийт албан хаагдад сургалт явуулж холбогдох гомдлын дагуу дотоод хяналт, шалглалт явуулахад гаалийн байгууллагын албан хаагчдаас шалтгаалсан буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй байна.
12. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч комисsar Ж.Мөнхсүлдийн 2023 оны 12 дугаар сарын 06 өдрийн Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу Гаалийн төв лабораториид гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгаж тайланг ирүүлэх талаар хугацаатай даалгавар өгч Гаалийн төв лаборатороос хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг АТГ-т 2024 оны 01 сарын 05-ны өдрийн 01-2/52 тоот албан бичгээр хүргүүлсэн.
13. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсээс 2024 оны 02 сарын 23-ны өдрийн 05/3489 тоот албан бичгээр Гаалийн ерөнхий газрын харьяа бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн дарга Э.Л-д холбогдох "Солонгос улсаас автомашин нийлүүлэгчдийн холбоо" ТББ-гаас гаргасан гомдлыг харьяаллын дагуу Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн бөгөөд тус гомдол, мэдээллийн дагуу албаны дотоод шалгалтыг хийж авлигатай тэмцэх газарт 2024.03.21-ний өдөр 01-5/1071 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.
14. Иргэн Чимэдсүрэнгийн Чинцоожоос "1111" утсаар ирсэн гомдол "Гашуунсхайт дахь гаалийн газрын дарга Ганбаяр нь ажлаа хийхгүй байна. Хүмүүсээс асуухаар 7 хоногоор ирдэггүй гэж байна. Холбогдох байгууллагад нь мэдэгдэж өгнө үү"-д шалгах ажиллагаа явуулахад үндэслэлгүй мэдээлэл

байсныг тогтоож, гомдол гаргагчид утсаар мэдэгдсэн. Гомдол гаргагч нь Ганбаяр даргатай биечлэн уулзаж хүнээс сонссонoo хэлсэн талаар танилцуулсан байна.

15. Иргэн Наранбаатарын Батаагаас Төрийн цахим сүлжээгээр ирсэн ЗТГ-01-212 дугаартай гомдол "02214101624130373 мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн 163800км гүйлттэй автомашин авсан гэтэл [autobox.mn](http://autobox.mn) сайт дээр 363793км-ийн гүйлттэй байна. Уг байцаагчид арга хэмжээ авч өгнө үү" -д шалгалтын ажиллагаа явуулж бүрдүүлэлт 363793км-ын заалттайгаар хийгдсэнийг тогтоож гаалийн байгууллагад хамааралгүй гэдгийг гомдол гаргагчид тайлбарлаж мэдэгдсэн.
16. Засгийн газрын 1111 төвд иргэн Н.Төмөрбаатараас манай газар дээр хууль бусаар их хэмжээний модны суулгац оруулж ирсэнийг цагдаагийн байгууллагад гомдол гаргаж шалгуулж байгаа энэ талаар холбогдох байгууллагад хэлж шалгуулж өгнө үү гэх гомдлыг шалгаж "Н.Төмөрбаатарт тухайн асуудлыг Цагдаагийн байгууллагаар шалгуулах талаар зөвлөгөө өгсөн" байна.
17. Эс Жи Эс Ай И Монгол" ХХК, түүний ажилтан Б.Бямбасүрэнгийн 2024.05.01-ний өдрийн 88009213 дугаарын утаснаас гаалийн лавлах 1800-1281 дугаарын утсанд УХШИГГ-ын албан хаагчидтай холбогдуулан гаргасан гомдлыг шалгахад гомдол гаргагчийн гомдолд дурдсан "ажлаа мэдэхгүй олон дахин явуулж байна, 1 сар явж байна" гэх асуудал тогтоогоогүй тул гомдлыг хааж шийдвэрлэсэн. Энэ тухай Гомдол гаргагч "Эс Жи Эс Ай И Монгол" ХХК-ийн ажилтан Б.Бямбасүрэн /88009213/ - д 2024.05.30-ны өдрийн 12:05 цагт мэдэгдсэн. Гомдолтой холбоотойгоор УХШИГГ-ын 2 албан хаагч, "Ди Эйч Эл" ХХК-ийн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон гомдол гаргагч Б.Бямбасүрэн нараас тайлбар гаргуулан авсан.
18. СЭГГ-ын үйл ажиллагаа, албан хаагчид холбогдуулан "2024.06.02-ны өдөр Алтанбулаг

					<p>боомтоор орж ирэхэд өндөг, сүүг минь хураана гээд оруулаагүй" гэх асуудлаар МУ-ын иргэний "1111" төвд гаргасан 2024.06.04-ний өдрийн гомдлыг хүлээн авч шалгахад тухайн иргэн нь тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчилд холбогдсон 720 ширхэг өндгийг хурааж, ЗТХ-ийн 11.21.11-д заасны дагуу 100,000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна.</p> <p>19. "Санчир-Үндрах" ХХК-ийн 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 01/193 дугаартай "ГЕГ-ын Бурдүүлэлтийн дараах шалгалтын газрын албан хаагч болон тухайн ААН-ийн 2023 онд гаргасан гомдол, мэдээлэл, "Чоноголтрайд" ХХК-д хийсэн бурдүүлэлтийн дараах шалгалт"-тай холбогдуулан гаргасан гомдлыг БДШГ-ын 2024.05.28-ны өдрийн №101/24 дугаартай Дотоод зурвасаар ирүүлснийг 2024.05.30-ны өдөр хүлээн авч шалгаж байна.</p>		
5	Гаалийн байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийх, гарсан үр дүнгээр зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцсон байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуйж ажилласан.	- Гаалийн байгууллагын хэмжээнд албан шалгалтыг гүйцэтгэж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. - Шалгалтын мөрөөр зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцсон байна.	<p>1. Замын-Үүд боомтоор 2023 онд улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлийг "хүчингүй" төлөvt оруулсан болон гаалийн байгууллагын бүтгэлгүй нэвтрүүлсэн үйлдлийг нягтлан шалгах ажлын хэсгийг 3 удаа эохион байгуулж, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хүчингүй болгосон буюу бүртгэл хийгээгүй нэр бүхий 14 гаалийн улсын ахлах байцаагчаас тайлбар авлаа. Холбогдох бусад мэдээллийг БНХАУ-ын гаалийн байгууллага болон ХХЕГ-аас авч тээврийн хэрэгслийн бүртгэлийг нягтлан шалгаж "улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгсэл нэвтрүүлсэн байж болзошгүй" гэх үйлдэл байх тул Цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн. Тус зөрчлийг Цагдаагийн байгууллагаас Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн тухай албан тоот ирүүлсэн байна. Дээрх алдаа дутагдалтай холбоотойгоор ГЕГ-ын Хяналт, бурдүүлэлтийн газарт "Замын-Үүд боомтоор Улсын хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийн бүртгэл гарч болзошгүй эрсдэлийг судалж дүгнэлт хийж, санал танилцуулах. Мөн тээврийн хэрэгслийн бүртгэл, шинээр бүртгүүлэх болон хуучин бүртгүүлсэн тээврийн хэрэгслийн холбогдох</p>	01-01 06-05	100

					<p>мэдээлэл, тээврийн хэрэгслийн болон чиргуулийн жин нягтлан шалгах тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж үр дүнг 2024.07.05-ны өдөр танилцуулах”, ГЕГ-ын Сахилгын хорооноос ГЕГ-ын Хорио цээрийн хэлтэст “Харьяа гаалийн газар, хороодын ариутгалын хураамжийн бүртгэлийг Гаалийн мэдээллийн автоматжуулсан системд тээврийн хэрэгсэл, жолооч, тээвэрлэж буй барааны мэдээллийг бүрэн гүйцэд оруулан цахимжуулах ажил, арга хэмжээ зохион байгуулж үр дүнг 2024.07.05-ны өдөр танилцуулах” чиглэлүүдийг хүргүүлээд байна.</p> <p>2. “Нэгун.мн” сайтын мэдээллээр ЧХОУНБГГ-ын албан хаагчидтай холбоотой зөрчлийн мэдээлэлд дотоод шалгалт хийж, тус зөрчилд холбогдох 4-н албан хаагчийн гаргасан зөрчлийн материалыг баримтжуулж Авлигатай тэмцэх газарт “Мэдээлэл шалгуулах тухай” 01-5/1279 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>3. УХШИГГ-ын албан хаагчидтай холбоотой гомдлын дагуу албаны дотоод шалгалтыг зохион байгуулж, ГЕГ-ын даргад танилцуулан ДХАБХ-ийн дарга Л.Очгэрэлээс 2024 оны 02 дугаар сарын 26 өдрийн 01-2.1/716 тоот албан бичгээр ажлын чиглэл хүргүүлж, гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааны доголдол дутагдлын талаар дурдаж, гарч байгаа зөрчил дутагдлыг арилгуулж бодит арга хэмжээ зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг авч ажиллаа. Тус газрын гаалийн хяналт шалгалтын зүгээс дахин ийм төрлийн алдаа дутагдал гараагүй байна.</p> <p>4. АТГ-ын № 06/8052 тоот албан бичгийн дагуу Мөрдөгч, комиссар Б.Алтанцэцэгийн өгсөн үүрэг даалгаврын дагуу Улаанбаатар хотын Улиастайд байрлах тухайн аж ахуйн нэгжийн байранд очиж гацуур модны дээж болох 2 том суулгацыг авчирсан. Хан-Уул дүүрэгт байрлах Хабулл лабораторид өгч АТГ-т хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--	---	--

**Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах**

6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг	Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн	01-01 06-05	100
---	--------------------------------------	-------------------------	--	--	--	----------------	-----

	ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ		Чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнасан.	хангаж, тухай бүр тайланг хүргүүлсэн байна.	өөрчлөлтийн хөтөлбөр”, ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/123 дугаар “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан бүтцийн дагуу Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс байгуулагдсантай холбогдуулан “Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг шалгур үзүүлэлтийн хамтаар дахин боловруулж МЗХ-аар батлуулсан.		
7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлagnana.	<ol style="list-style-type: none"> <li>1. Тайлант хугацаанд тус хэлтэст Авлигатай тэмцэх газраас-7 удаа, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албанаас -5 удаа, Захиргааны хэргийн шүүхээс -1 удаа, Хил хамгаалах ерөнхий газраас 2 удаагийн албан тоот ирүүлсэнд Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хариуг бэлтгэн хугацаанд нь хүргүүлсэн байна. Мөн хугацаанд харьяа газар, хороодоос 43 удаагийн албан тоот, хуулийн этгээдээс 1 удаагийн албан тоот ирүүлсэн байна. Мөн тус газраас хууль хяналтын байгууллагад 15 удаагийн албан тоотыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 245 хуудас баримтыг нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлж ажилласан.</li> <li>2. Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 06 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “ГЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн А/123 дугаар “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан бүтцийн дагуу ЗББНДБ болон харьяа газар хороодын дарга нарын ажлын байрны тодорхойлолтод оруулах өөрчлөлтийг боловсруулж, захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.</li> <li>3. Мөн “Мэдээллийн болон программ хангамж, дотоод сүлжээний аюулгүй байдалд хяналт тавих”-тай холбоотой журам төслийн шатандаа явж байна.</li> <li>4. 2023 оны 05 дугаар сард батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гаалийн байгууллагын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-ны гишүүн сонгох,</li> </ol>	01.01-06.05	100

					сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажиллагаанд оролцож ажилласан.		
8	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нэгжийн үйл ажиллагаанд тухай бүр эрсдэл тооцож ажилласан.	- Нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг таньж тогтоон, сан бүрдүүлсэн байна. Дүн шинжилгээ хийж, эрсдэл бууруулах арга хэмжээг тухай бүр авсан байна.	<p>ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ын хурээнд дараах байдлаар нэгжийн эрсдэлийг тооцож ажиллаа.</p> <p>Нэгжийн эрсдэлийг таньж тогтоох зорилгоор хэлтсийн нийт албан хаагчдын хурал хийж, санал асуултгыг ГУАБ, ГУБ нараас авч, дүнт нэгтгэн нэгжийн эрсдэлийг дараах байдлаар тогтоож ажиллалаа.</p> <p>Үүнд: Тус журмын 2 дахь хэсэгт заасан зарчмыг баримтлан 3 дахь хэсгийн 3.1.12-т заасан “үйл ажиллагааны тувшиний эрсдэл”-ийг тодорхойлов.</p> <p>1. 3.2.1 <b><u>“Хүний нөөцийн хүчин зүйл”</u></b>: -ийн эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тус нэгж нь тайлант хугацаанд /батлагдсан бүтцийн дагуу 1-2 албан хаагч/ дутуу ажиллав. Цаашид нэгжийн “албан тушаалын тодорхойлолт”-ын шалгуурт нийцүүлэн албан тушаалтыг томилуулан ажиллуулах шаардлагатай байна.</li> <li>• Дээрх эрсдэлтэй холбоотойгоор эхний ээлжинд ШИГГ-ын ГУБ Т.Сайн-Оюутаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ГЕГ-ын хүний нөөцийн хэлтэст 2024 оны 02-р срын 11-ний өдөр 24/13 тоот дотоод зурvas илгээж шийдвэрлүүлсэн байна.</li> <li>• Мөн дутуу орон тоог нөхөн томилуулахаар ГЕГ-ын ХХХ-т албан хаагчийн нэрсийн /томилуулах/ санлыг дотоод зурвасаар хүргүүлсэн.</li> </ul> <p>2. 3.2.2 <b><u>“Хууль тогтоомжийн хүчин зүйлс”</u></b>: -ийн эрсдэл</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг эцэслэн батлуулах;</li> <li>• Үүнтэй холбогдуулан ГЕГ-ын даргад танилцуулж, чиглэл авсан. Тушаал эцэслэн батлагдахыг хүлээж байна.</li> <li>• ДХАБХ байгуулагдсантай холбогдуулан ЗГ-ын 311-р тогтоолоор батлагдсан “Дотоод хяналт шалгалт хийх нийтлэг журмын дагуу гаалийн байгууллагын хэмжээнд мөрдэж ажиллах “Дотоод хяналт шалгалтын журам эцэслэн батлагдаагүй байгаа нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд бэрхшээл үүсгэж байна.</li> </ul>	01-01 06-05	100

					<p>3. 3.2.3 <b><u>“Мэдээллийн технологи, программ хангамжийн хучин зүйлс”</u>-ийн эрсдэл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Кибер аюулгүй байдлын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, “ГЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/255 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлын журам”-уудын дагуу хариуцан албан хаагчдыг томилох гэх мэт эрсдэлт хучин зүйлсийг нэгжийн эрсдэлээр тодорхойлж байна.</li> <li>Дээрх эрсдэлтэй холбоотойгоор ДХАБХ-ийн ГУБ Ж.Батцэнгэлийг Удирдлагаын академи, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэхнийтийн төв, ШИТИС-иас хамтран зохион байгуулсан “Мэдээллийн аюулгүй байдал” сургалтанд хамруулсан.</li> <li>Нийт албан хаагчдийг ЗШШ, мөнгө угаахтай тэмцэх чиглэлийн сургалтад хамруулсан.</li> <li>Гомдол мэдээлэл болон сошал мэдээллийг үндэслэн албаны шалгалтыг явуулахад техник, тоног төхөөрөмжийн хоцрогдол, сүлжээний хяналт тавих эрхийн хязгаарлалттай байгаа нь асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.</li> </ul>		
9	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хугацаа хоцроосон үүрэг даалгаваргүй ажилласан. Мөн</p>	<p>- Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.</p> <p>- ГЕГ-ын ЗБНДБ болон ХГГХ-дод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.</p>	<p>1. 2024 оны эхний хагас жилийн байдаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлж ажилласан. Тайлант хугацаанд гаалийн газарт хороодод 01-2.1/716, 01-2/688, 01-2.1/502, 01-5/1741 тоот албан бичгүүдээр ажлийн чиглэл хугуулж ажилласан.</p> <p>2. Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүдэд 47 дотоод зурvas явуулж, 57 дотоод зурvasыг хүлээн авч холбогдох хариуг өгч ажиллалаа. Үүнд ГЕГ-ын бүтцийн нэгж дэргэдэх байгууллагаас ирүүлсэн дотоод зурvasыг төрлөөр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Лавлагаа, мэдээлэл ирүүлэх тухай – 7</li> <li>Гомдол шилжүүлэх тухай – 2</li> <li>Дотоод зурvas, лавлагааны хариу – 11</li> </ul>	01-01 06-05	100

			<p>албаны чиг Үүргийн дагуу ГЕГ-ын дарга, ЗТАБГ-ын даргаас тусгайлан өгөгдсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд хийж түйцэтгэн, биелэлтийг тухай бүр танилцуулж, үр дүнг тооцон ажилласан. Нэгжийн 2023 оны үнэлгээ 5 байсан.</p>		<ul style="list-style-type: none"> <li>• Тайлан, материал хүргүүлэх тухай – 7</li> <li>• Санал авах тухай – 15</li> <li>• Санал хүргүүлэх тухай – 2</li> <li>• Асуудал шийдвэрлүүлэх тухай – 1</li> <li>• Тайлан ирүүлэх, үүрэг болгох тухай – 6</li> </ul> <p>Манай хэлтсээс бусад нэгжруү нийт 47 дотоод зурвасыг хүргүүлсэн байх ба тэрлөөр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Лавлагаа, мэдээлэл, материал ирүүлэх тухай – 11</li> <li>• Лавлагаа, мэдээлэл хүргүүлэх тухай – 6</li> <li>• Тодорхойлолт хүргүүлэх тухай – 1</li> <li>• Дотоод зурвасын хариу – 4</li> <li>• Материал хүргүүлэх тухай – 6</li> <li>• Санал хүргүүлэх тухай – 14</li> <li>• ГУБ томилуулах тухай – 1</li> <li>• Хүсэлт гаргах, асуудал шийдвэрлүүлэх тухай – 3</li> <li>• Хамтран ажиллах тухай – 1</li> </ul> <p>3. Гаалийн байгууллагын дотоод сүлжээгээр “үүрэг даалгавар” хэсэгт 2 удаагийн зөвлөмж, 4 үүрэг даалгавар өгснийг хугацаанд биелүүлж хариуг илгээсэн.</p>		
10	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, түйцэтгэлээр	<p>Алба хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмж, түйцэтгэх ажлын чанаар, ажлын байрны чиг үүрэг, онцлогт тохируулан хэрхэн ажиллах, ажилтнуудын ажлын цаг ашиглалтын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, тухай бүр хяналт тавин ажилласан.</p>	<p>Ажлын цаг ашиглалтыг өмнөх оны мөн үеэс бууруулаагүй байна.</p>	<p>Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэгжийн бүх албан хаагч цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж хэвшсэн бөгөөд зайлшгүй шаардлагатай уед албаны ажлаар гадуур ажиллах, хувийн чөлөө авсан тохиолдол бүрд СЕРР-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. Тайлант хугацаанд алба хаагчдаас ажил тасалсан зөрчил байхгүй.</p> <p>Нэгжийн чиг үүргийн онцлогоос хамаарч албан хаагчид илүү цагаар ажиллах, гар утасны бэлэн байдлыг 24/7 цагаар ханган ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ГУБ Б.Батхолбоо нь 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс 05дугаар сарын 24-ний өдрийн хороонд ар гэрийн гачигдлын улмаас ажлын 4 хоногийн цалинтай чөлөө авсан ба чөлөө авах хүсэлтийг Серг программар илгээсэн болно.</li> <li>2. ГУБ Н.Лхагвадэлгэр нь 2024 оны 05 сарын 17-ны өдрөөс 2024 оны 05 сарын 31-ний өдрийн хороонд чөлөө авах хүсэлтээ Серг программаар илгээн албан ёсоор чөлөө авсан болно.</li> <li>3. ГУБ Т.Сайн-Оюут нь тайлант хугацаанд ажил таслаагүй бөгөөд 40.5 цагаар илүү ажилажээ. Шалтгаан нь: 2023 онд ЗҮ боомтоор бүртгэлгүй</li> </ol>	01-01 06-05	100

					<p>нэвтэрсэн 33 тээврийн хэрэгсэлд холбогдох нэр бүхий 2 ГУАБ-д холбогдох зөрчлийг шалгах, мөн боомтоор 2023 онд 242 тээврийн хэрэгслийн тайланг нэгтгэх ажлаар 40.5 цагаар илүү ажилласан байна.</p> <p>4. ГУАБ Б.Одгэрэл нь нэгжийн үйл ажиллагааны онцлог, дотоод хяналт, шалгалтыг шуурхай хийх болон цаг үеийн сургалт, мэдээлэл хүргүүлэх ажлын бэлтгэл ажлаас шалтгаалж 10-н цаг илүү ажилласан байна. /УБГГ, ЦБТ, ЧХОУНБ, УХШИГГ-дад хийсэн 4 удаа/</p>		
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан.</li> <li>- Гаалийн байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан.</li> <li>- "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд гаалийн байгууллагын 2023 онд хийх ажлын дэд төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн үйл ажиллагаанд тухай бүр орж ажилласан байна.</li> <li>- Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</li> <li>- "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд гаалийн байгууллагын 2024 онд хийх ажлын дэд төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</li> </ul>	<p>1. ГЕГ-ын даргын баталсан удирдамжын дагуу УБГГ, ЧХОУНБГГ, УХШИГГ, БЦТ-ийн нийт албан хаагчдад "Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийн мониторинг", "ДХАБХ-ийн ажлын чиглэл, чиг үүрэг, бүтэц орон тооны талаарх танилцуулга мэдээллийг хийв. Тум мэдээллээр ГЕГ-ын хэмжээнд 2021-2024 онуудад сахилгын зөрчилд холбогдож, сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагчдын мэдээлэл, 2024 оны эхний хагас жилд гаалийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчидтай холбоотой ЗГ-ын 11-11, 1800-1281 утсаар ирсэн гомдол, мэдээлэллийн дагуу ГЕГ-ын ДХАБХ-т шалгагдсан сахилгын болон, ёс зүйн зөрчлийн товч танилцуулгыг хийлээ. Гаалийн байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийгдсэн ажлыг танилцуулан, албан хаагчдад анхааруулга, сээрэмжлүүлэг өгсөн.</p> <p>2. "Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" болон "Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээ"-г сайжруулах төлөвлөгөөнд нэгжийн холбогдох тайланг гаргаж чиглэл хариуцсан нэгжид хүргүүлсэн.</p> <p>3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018.01.23-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам" – д заасны дагуу гаалийн байгууллагаас Үндэсний аюулгүй байдлын Ажлын албанд тухай бүр, өдөр бүр, сар бүр, улирал бүр хүргүүлэх шуурхай болон танилцуулах мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд</p>	01-01 06-05	100


			хангаж ажилласан.		4. Гаалийн байгууллагын 2024 онд хийх ажлын дэд төлөвлөгөө"-ний дагуу ажлын тайланг хагас жилээр дүгнэсэн тайлангийн ажил хийгдэж байна. 5. Тус газрын ГУБ Батцэнгэл нь 2024 оны 01-02 дугаар саруудад УИХ-ын хянан шалгах түр хороон /нүүрсний сонсголтой холбоотой/-д ажилласан. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох зорилготойгоор 7 хоног бүрийн баасан гараг бүр зохион байгуулагддаг "Мэдээллийн цаг" – ийн 2024.05.03-ны өдрийн мэдээллийн цагт "Гаалийн байгууллагын дотоод хяналтын чиг үүрэг, ойлголт"-ын талаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн дарга Л.Очгэрэл мэдээлэл хийж, сонирхсон асуултад хариулт өгсөн.	
--	--	--	-------------------	--	---	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
1	"Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник" сэдэвт сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Сургалтад хамрагдаж батламж авсан байна.	Тус сургалтад ажлын 5 хоног хамрагдан ажилттай суралцаж, батламж авсан.	01-01 06-05	100

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
( Албан тушаал )



/ Л.Очгэрэл/  
( Нэр, гарын үсэг )

2024 оны 06 сарын 10

( Огноо )

**ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА ЛУВСАНСАМДАНГИЙН ОЧГЭРЭЛИЙН  
2024 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар  
Нэгжийн нэр: Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		59.5

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		14
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх		14
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			14

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	13
2	Удирдан зохион байгуулах	12
3	Асуудал шийдвэрлэх	12
4	Манлайлах	12
5	Багаар ажиллах	15
6	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	13
<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>		13

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	59.5
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14

3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
	<b>Нийт оноо=</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	86,5

Үнэлгээ өгсөн:

Гаалийн өрөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч

(Р.Огтонжаргал)

2014. 06. 19

(огноо)

Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:

Дотоод хяналт, аюулгүй  
байдлын хэлтсийн дарга

Нэгжийн дарга:

(Л.Очгэрэл)

2014. 06. 21

(огноо)